

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3. Аудитын тайлан.....	15
3.1. Ерөнхий зүйл.....	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	16
3.4. Материаллаг байдал	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	19
Залруулсан алдаа.....	19
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	19
Аудитын зөвлөмж.....	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	20
4. Менежментийн захидал	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22



ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГА Х.БАТЖАРГАЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.02.25 № 07/500
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний хөгжлийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үндэсний хөгжлийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 41 зорилтын хүрээнд 66 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>490,020,314,235.39</u>	<u>716,743,080,788.66</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	26,578,185,126.76	14,324,841,701.04
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	26,578,185,126.76	14,324,841,701.04
3121	Төгрөг	26,578,185,126.76	14,324,841,701.04
31211	Төрийн сангийн харилцах	26,578,185,126.76	14,324,841,701.04
33	АВЛАГА	182,758,655.00	35,108,987.17
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,805,914.00	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	154,834,819.00	00.00
335	Бусад авлага	25,117,922.00	35,108,987.17
3351	Байгууллагаас авах авлага	25,117,922.00	35,108,987.17
35	БАРАА МАТЕРИАЛ	38,415,247.09	392,909,577.09
354	Хангамжийн материал	38,415,247.09	392,909,577.09
35410	Бичиг хэргийн материал	11,680,410.00	3,444,500.00
35420	Аж ахуйн материал	26,158,516.09	29,053,516.09
35440	Түлш, шатах тослох материал	576,321.00	1,840,261.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	358,571,300.00
36	НӨӨЦИЙН БАРАА	463,220,955,206.54	701,990,220,523.36
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	463,220,955,206.54	701,990,220,523.36
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>241,597,046.34</u>	<u>205,723,310.29</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	241,597,046.34	205,723,310.29
392	Биет хөрөнгө	241,118,546.34	205,343,810.29
39203	Авто-тээврийн хэрэгсэл	36,850,000.00	50,850,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-36,850,000.00	(40,349,999.98)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	394,142,765.83	373,747,939.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	-183,340,494.26	(202,887,739.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	135,309,251.52	135,309,251.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	-105,411,976.75	(111,744,640.75)
39217	Ном	419,000.00	419,000.00
393	Биет бус хөрөнгө	478,500.00	379,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,403,000.00	4,323,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-10,924,500.00	(3,943,500.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>490,261,911,281.73</u>	<u>716,948,804,098.95</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>7,917,643,441.00</u>	<u>14,324,869,701.04</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,917,643,441.00	14,324,869,701.04
413	Өглөг	7,917,643,441.00	14,324,869,701.04
4136	Бусад өглөг	7,917,643,441.00	14,324,869,701.04
41361	Байгууллагад төлөх өглөг	7,917,643,441.00	14,324,869,701.04
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>482,344,267,840.73</u>	<u>702,623,934,397.91</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	482,344,267,840.73	702,623,934,397.91

512	Хуримтлагдсан үр дүн	482,344,267,840.73	702,601,084,397.91
51210	Өмнөх үеийн үр дүн	343,439,914,435.61	482,552,660,540.73
51220	Тайлант үеийн үр дүн	138,904,353,405.12	220,048,423,857.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	22,850,000.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>490,261,911,281.73</u>	<u>716,948,804,098.95</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	147,217,284,652.88	333,066,695,035.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,061,001,620.20	10,734,167,405.38
120	Нийтлэг татварын бус орлого	8,061,001,620.20	10,734,167,405.38
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,061,001,620.20	10,734,167,405.38
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,890,210,686.20	10,719,707,405.38
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,098,000.00	460,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	149,692,934.00	14,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	139,156,283,032.68	322,332,527,630.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	138,990,037,575.68	322,332,527,630.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,625,588,000.00	1,359,435,400.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	137,364,449,575.68	320,973,092,230.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	166,245,457.00	00.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	166,245,457.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,312,931,247.76	113,018,271,178.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,312,931,247.76	113,018,271,178.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,266,318,689.83	112,952,465,889.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	649,651,616.17	735,377,829.00
210101	Үндсэн цалин	556,241,927.17	533,120,129.84
210102	Нэмэгдэл	40,100,000.00	152,716,299.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,345,500.00	49,541,400.00
210104	Урамшуулал	11,964,189.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,945,513.83	98,859,877.00
210201	Тэтгэврийн даатгал	57,771,425.23	69,705,477.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,796,638.34	7,288,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,437,310.65	5,830,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,359,327.67	1,457,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,580,811.94	14,577,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,357,550.00	72,240,650.00
210301	Гэрэл цахилгааны зардал	19,410,700.00	33,136,583.00
210302	Түлш, халаалтын зардал	25,070,754.00	25,427,683.00
210303	Цэвэр, бохир усны зардал	7,876,096.00	13,676,384.00
2104	Хангамж, бараа материалын зардал	124,007,171.44	73,649,998.40
210401	Бичиг хэрэг	23,060,157.50	12,085,110.00
210402	Тээвэр, шатахуун	49,775,236.42	20,858,691.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,603,237.02	27,558,047.40
210404	Ном, хэвлэл	20,319,600.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,529,381.25	13,148,150.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,719,559.25	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,748,029.00	11,186,200.00
210601	Багаж хэрэгсэл	495,000.00	10,983,200.00

210604	Урсгал засвар	1,253,029.00	203,000.00
2107	Томилолт, зочны зардал	24,520,212.00	10,763,686.73
210701	Гадаад албан томилолт	2,804,632.00	3,119,011.73
210702	Дотоод албан томилолт	18,986,280.00	6,786,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,729,300.00	858,675.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	394,889,482.05	15,219,065,914.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	369,771,515.05	15,214,942,793.10
210803	Даатгалын үйлчилгээ	298,920.00	281,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	92,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	24,819,047.00	3,325,421.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	424,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,934,199,115.34	96,731,321,734.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,906,080,744.00	96,675,048,198.52
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,118,371.34	56,273,536.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,612,557.93	65,805,288.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,870,000.00	29,060,247.10
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	20,693,647.10
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,870,000.00	8,366,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,742,557.93	36,745,041.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,742,557.93	36,745,040.90
	Хөрөнгийн	00.00	00.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>138,904,353,405.12</u>	<u>220,048,423,857.18</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>138,904,353,405.12</u>	<u>220,048,423,857.18</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	150,138,542,160.88	333,207,529,854.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,960,574,314.20	10,720,167,405.38
120	Нийтлэг татварын бус орлого	10,960,574,314.20	10,720,167,405.38
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,960,574,314.20	10,720,167,405.38
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,890,210,686.20	10,719,707,405.38
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,060,473,000.00	460,000.00
120009	Бусад орлого	9,890,628.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	139,177,967,846.68	322,487,362,449.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	138,990,037,575.68	322,332,527,630.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,625,588,000.00	1,359,435,400.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	137,364,449,575.68	320,973,092,230.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	187,930,271.00	154,834,819.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	187,930,271.00	00.00
131107	Урьд оны үлдэгдлээс санхүүжих - Нэмэлт	00.00	154,834,819.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	8,753,201,791.00	24,481,381,250.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,753,201,791.00	24,481,381,250.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,552,024,414.07	24,398,252,042.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	656,239,900.00	732,571,915.00
210101	Үндсэн цалин	511,090,800.00	530,314,215.84
210102	Нэмэгдэл	99,868,500.00	152,716,299.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,280,600.00	49,541,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,029,800.00	98,859,877.00
210201	Тэтгэврийн даатгал	55,780,400.00	69,705,477.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,562,300.00	7,288,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,249,900.00	5,830,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,312,400.00	1,457,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,124,800.00	14,577,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,149,100.00	61,149,100.00
210301	Гэрэл цахилгааны зардал	29,439,400.00	29,439,400.00
210302	Түлш, халаалтын зардал	21,730,500.00	21,730,500.00
210303	Цэвэр, бохир усны зардал	9,979,200.00	9,979,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	89,960,594.02	68,319,417.00
210401	Бичиг хэрэг	15,506,160.00	9,375,650.00
210402	Тээвэр, шатахуун	49,254,000.00	9,938,267.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	22,079,237.02	32,660,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,121,197.00	16,345,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,444,529.00	11,243,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	625,000.00	11,040,200.00

210604	Урсгал засвар	1,819,529.00	203,000.00
2107	Томилолт, зочны зардал	28,385,532.00	10,623,311.73
210701	Гадаад албан томилолт	2,804,632.00	3,119,011.73
210702	Дотоод албан томилолт	23,141,950.00	6,786,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,438,950.00	718,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	429,764,582.05	18,462,540,811.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	404,624,615.05	18,458,285,690.10
210803	Даатгалын үйлчилгээ	298,920.00	281,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	22,000.00	92,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	24,819,047.00	3,325,421.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	556,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,202,050,377.00	4,952,944,410.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,202,050,377.00	4,952,944,410.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	201,177,376.93	83,129,207.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,600,000.00	29,060,247.10
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		20,693,647.10
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,600,000.00	8,366,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	187,577,376.93	54,068,960.87
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,742,557.93	54,068,960.47
213304	Хөрөнгийн	0.00	0.40
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	154834819.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>141,385,340,369.88</u>	<u>308,726,148,603.88</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	138,136,498,240.68	320,979,492,029.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	138,136,498,240.68	320,979,492,029.60
2200	Дотоод эх үүсвэрээр	138,136,498,240.68	320,979,492,029.60
220001	Барилга байгууламж	137,364,449,575.68	320,979,492,029.60
223001	Бусад хөрөнгө	754,580,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,468,665.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(138,136,498,240.68)</u>	<u>(320,979,492,029.60)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	3,248,842,129.20	(12,253,343,425.72)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	23,329,342,997.56	26,578,185,126.76
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,578,185,126.76	14,324,841,701.04

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	343,439,914,435.61	343,439,914,435.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	343,439,914,435.61	343,439,914,435.61
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	138,904,353,405.12	138,904,353,405.12
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	482,344,267,840.73	482,344,267,840.73
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	208,392,700.00	208,392,700.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	482,552,660,540.73	482,552,660,540.73
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	22,850,000.00	-	22,850,000.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	220,048,423,857.18	220,048,423,857.18
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	22,850,000.00	702,601,084,397.91	702,623,934,397.91

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	324,989,871,100.00	322,295,782,588.70	(2,694,088,511.30)	99.2
УРСГАЛ ЗАРДАЛ	1,497,593,400.00	1,322,690,359.10	(174,903,040.90)	88.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,413,343,900.00	1,293,630,112.00	(119,713,788.00)	91.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	728,865,700.00	728,865,700.00	-	100.0
Үндсэн цалин	563,301,600.00	526,608,000.84	(36,693,599.16)	93.5
Нэмэгдэл	120,283,500.00	152,716,299.16	32,432,799.16	127.0
Унаа хоолны хөнгөлөлт	45,280,600.00	49,541,400.00	4,260,800.00	109.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,396,600.00	98,396,600.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	69,242,200.00	69,242,200.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	7,288,600.00	7,288,600.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	5,830,900.00	5,830,900.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	1,457,600.00	1,457,600.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	14,577,300.00	14,577,300.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,149,100.00	61,149,100.00	-	100.0
Гэрэл, цахилгаан	29,439,400.00	29,439,400.00	-	100.0
Түлш, халаалт	21,730,500.00	21,730,500.00	-	100.0
Цэвэр, бохир ус	9,979,200.00	9,979,200.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	68,373,900.00	68,319,417.00	(54,483.00)	99.9
Бичиг хэрэг	9,381,000.00	9,375,650.00	(5,350.00)	99.9
Тээвэр, шатахуун	9,979,200.00	9,938,267.00	(40,933.00)	99.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,660,400.00	32,660,400.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,353,300.00	16,345,100.00	(8,200.00)	99.9
Эд хогшил, урсгал засварын зардал	17,643,000.00	17,643,000.00	-	100.0
Багаж, техник хэрэгсэл	17,440,000.00	17,440,000.00	-	100.0
Урсгал засвар	203,000.00	203,000.00	-	100.0
Томилолт, зочны зардал	7,570,300.00	7,504,300.00	(66,000.00)	99.1
Дотоод албан томилолт	6,826,000.00	6,786,000.00	(40,000.00)	99.4
Зочин төлөөлөгч хүлээн авах	744,300.00	718,300.00	(26,000.00)	96.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	310,562,400.00	275,270,421.00	(35,291,979.00)	88.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	304,888,400.00	271,015,300.00	(33,873,100.00)	88.9
Даатгалын үйлчилгээ	836,200.00	281,100.00	(555,100.00)	33.6
Тээврийн хэрэгслийн татвар	222,900.00	92,100.00	(130,800.00)	41.3
Тээврийн хэрэгслийн оношилгоо	12,200.00	-	(12,200.00)	00.0

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,388,500.00	3,325,421.00	(63,079.00)	98.1
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,214,200.00	556,500.00	(657,700.00)	45.8
Бараа үйлчилгээний бусад зардал	120,782,900.00	36,481,574.00	(84,301,326.00)	30.2
Бараа үйлчилгээний бусад зардал	120,782,900.00	36,481,574.00	(84,301,326.00)	30.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,249,500.00	29,060,247.10	(55,189,252.90)	34.5
Засгийн газрын урсгал шилжүүлэг	19,875,000.00	-	(19,875,000.00)	00.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	19,875,000.00	19,875,000.00	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	64,374,500.00	29,060,247.10	(35,314,252.90)	45.1
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	55,691,200.00	20,693,647.10	(34,997,552.90)	37.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,683,300.00	8,366,600.00	(316,700.00)	96.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	323,492,277,700.00	320,973,092,229.60	(2,519,185,470.40)	99.2
Барилга байгууламж	323,492,277,700.00	320,973,092,229.60	(2,519,185,470.40)	99.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	324,989,871,100.00	322,295,782,588.70	(2,694,088,511.30)	99.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	324,989,871,100.00	322,295,782,588.70	(2,694,088,511.30)	99.9
Улсын төсвөөс санхүүжих	324,989,871,100.00	322,295,782,588.70	(2,694,088,511.30)	99.9
АЖИЛЛАГСДЫН ТОО	55	55	0	100.0
Удирдах ажилтан	2	2	0	100
Гүйцэтгэх ажилтан	50	50	0	100
Үйлчлэх ажилтан	3	3	0	100
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	55	55	0	100
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	52	52	0	100
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3	3	0	100

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		154,834,819.00
УРСГАЛ ЗАРДАЛ		154,834,819.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		137,510,899.43
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		3,706,215.00
Үндсэн цалин		3,706,215.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		463,277.00
Тэтгэврийн даатгал		463,277.00
Томилолт, зочны зардал		3,119,011.73
Гадаад албан томилолт		3,119,011.73
Дотоод албан томилолт		-
Бараа үйлчилгээний бусад зардал		130,222,395.70
Бараа үйлчилгээний бусад зардал		130,222,395.70
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		17,323,919.57
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		17,323,919.57
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		154,834,819.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		154,834,819.00
Урьд оны үлдэгдлээс санхүүжих - Нэмэлт		154,834,819.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Үндэсний хөгжлийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг газрын дарга Х.Батжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийг зохистой удирдаж авлага, өр, төлбөр үүсгэхгүй байх талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор Ц.Цэрэнхүү нар хэрэгжүүлэв.

Үндэсний хөгжлийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/51 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, хөгжлийн бодлогыг хүн амын нутагшилт, суурьшил, бүсчилсэн хөгжлийн болон орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хөрөнгө оруулалтын нэгдсэн болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг зохистой төлөвлөж улсын эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

- Улсын хөгжлийн цогц бодлого, урт, дунд хугацааны хөгжлийн төлөвлөлт, хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах;
- Бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулах, салбар хоорондын харилцан ажиллагааг зохицуулах;
- Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дэмжлэг үзүүлэх, концесс, төр хувийн хэвшлийн түншлэлийн бодлого хэрэгжүүлэх;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд хийгдэх судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах;
- Төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах;
- Үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод хяналт шалгалтын санал дүгнэлтээр дэмжлэг үзүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”-ын 9 дүгээр хавсралт *“Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ”*

- Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоол “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай”
- Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Үндэсний хөгжлийн газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хяналт шинжилгээ, дотоод аудитын хэлтэс нь www.shilendans.gov.mn сайтад байршуулсан Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээлэл тайлагнасан байдалд хяналт тавьж, үнэлгээ өгч ажилласан байна. Харин тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Тус газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны завсрын аудитаар балансын данстай холбоотой материаллаг алдаа, зөрчлүүд илэрсэн тул 2019 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгөөр сонголоо.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүү байдлын тайлангийн нийт хөрөнгийг суурь болгон 490,261,911.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,902,619.1 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үндэсний хөгжлийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 226,686,892.8 мянган төгрөгөөр буюу 46.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, өр төлбөр, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	26,578,185.1	14,324,841.7	-12,253,343.4
Авлага	182,758.7	35,109.0	-147,649.7
Бараа материал	463,259,370.5	702,383,130.1	239,123,759.6
Үндсэн хөрөнгө	241,597.0	205,723.3	-35,873.7
Нийт хөрөнгө	490,261,911.3	716,948,804.1	226,686,892.8
Өр төлбөр	7,917,643.5	14,324,869.7	6,407,226.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	482,344,267.8	702,623,934.4	220,279,666.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	490,261,911.3	716,948,804.1	226,686,892.8

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 14,324,841.7 мянган төгрөг болж 12,253,343.4 мянган төгрөгөөр буурсан нь хэрэгжсэн концессын техник хяналтын болон барьцаа хөрөнгийн төлбөр төлөгдсөнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 702,383,130.1 мянган төгрөг болж 239,123,759.6 мянган төгрөгөөр өссөн нь концессоор хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон зам, барилга байгууламжийг ашиглагч байгууллагад нь шилжүүлэх хүртэл бусад эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансанд 2020 оны хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 373,758,260.8 мянган төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлэхээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2020 оны 01/1607 дугаар албан бичгээр саналаа хүргүүлсэн боловч тайлант онд тогтоол гараагүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 14,324,869.7 мянган төгрөг болж 6,407,226.2 мянган төгрөгөөр буурсан нь хэрэгжсэн концессын техник хяналтын болон барьцаа хөрөнгийн төлбөр төлөгдсөнөөс шалтгаалжээ. Дансны үлдэгдлийн 99.9 хувь нь гүйцэтгэгч байгууллагуудад олгох барьцаа хөрөнгө байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 702,623,934.4 мянган төгрөг болж 220,279,666.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

Үндэсний хөгжлийн газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 185,849,410.4 мянган төгрөгөөр буюу 126.2 хувиар өссөн байна.

Улсын төсвөөс Чойр" дэд станцын өргөтгөл, шинэчлэлт төсөл, Оюутолгой-Цагаан суварга чиглэлийн агаарын шугам, дэд станц төсөл, Баянгол дүүргийн 38 дугаар сургуулийн барилга, Хан-Уул дүүргийн 300 ортой төрөх эмнэлгийн барилгын дуусгал, дэд бүтэц, Баянхонгор аймгийн Өлзийт сумын 100 ортой цэцэрлэгийн барилгын өргөтгөл, Алтай-Дарви чиглэлийн, Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн, Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн хатуу хучилттай авто зам төсөлд зориулан 320,973,092.2 мянган төгрөгийн хөрөнгийн санхүүжилт авсан нь орлогын өсөлтөд голлон нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 104,705,339.9 мянган төгрөгөөр буюу 13.6 дахин нэмэгдсэн нь дээр дурдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг концесс эзэмшигчдэд олгосонтой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны аудитын зөвлөмжийн дагуу 208,392.7 мянган төгрөгийн төсөл хөтөлбөрийн үр дүнд бий болсон судалгааны ажлын тайлангуудыг бараа материал дансанд орлого авч нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр тусгасан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зардлыг 7,144,035.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 5,646,441.7 мянган төгрөгөөр бууруулж 1,497,593.4 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн төлөвлөлт бодитой боловсруулаагүй байгааг харуулж байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 322,332,527.6 мянган төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс авч, хөрөнгө оруулалтын зардалд 320,973,092.2 мянган төгрөг, урсгал үйл ажиллагаанд 1,322,690.4 мянган төгрөгийг зарцуулж, 36,745.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 322,295,782.6 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь Засгийн газрын 2020 оны 114 дүгээр тогтоолоор Ковид-19 цар тахлаас шалтгаалан зарим зардал гаргахыг түр хугацаагаар зогсоосноос шалтгаалан хөрөнгө оруулалтын зардлыг 2,519,185.5 мянган төгрөгөөр, урсгал зардлыг 174,903.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өмнөх оны гадаад төсөл хөтөлбөрийн 154,834.8 мянган төгрөгийн авлагыг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Үүнээс 3,119.0 мянган төгрөгийг гадаад албан томилолтод, 4,169.5 мянган төгрөгийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулж, 130,222.3 мянган төгрөгийг төсөлд нь буцаан шилжүүлж, нийт 137,510.8 мянган төгрөгийг зарлага гарган, үлдэгдэл 17,323.9 мянган төгрөгийг Сангийн яамнаас авлага үүсгэн тооцоо нийлж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 39 мэдээллээс хугацаандаа оруулсан 32, хоцроосон 7 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4,439,158.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 91,100.0 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 6 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	4,439,158.7	2	4,439,158.7			100
Албан шаардлага	2	91,100.0	2	91,100.0			100
Зөвлөмж	6		6				100
Нийт дүн	10	4,530,258.7	10	4,530,258.7			100

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 554,010,031.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 550,780,746.3 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, 3,110,149.1 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 101,350.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 17,785.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, Концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон 185,115,000.0 мянган төгрөгийн ашиглагч байгууллагад шилжүүлэх хөрөнгийг барилга байгууламж дансаар орлого авч зарлага гаргасан байсныг залруулав.

Завсрын аудитаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, Концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон Баянгол дүүргийн 38-р сургуулийн 2,587,900.0 мянган төгрөгийн өртөгтэй барилга, Алтай-Дарви чиглэлийн 363,077,846.3 мянган төгрөгийн өртөгтэй хатуу хучилттай авто замыг тус тус ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй байсанд зөвлөмж өгсөн ба 2020 оны 01/1607 дугаар албан бичгээр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт концессын зүйлийг төрийн өмчид шилжүүлэх хүсэлт хүргүүлж, аудитын явцад шийдвэрлэгдсэн болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 3,229,284.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 3,110,149.1 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 101,350.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Алтай-Дарви чиглэлийн 98км, 165 км хатуу хучилттай авто зам төслийн техникийн хяналтаас хэмнэгдсэн 3,039,347.9 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байсанд завсрын аудитаар төлбөрийн акт тогтоосон.

2. Чойр дэд станцын өргөтгөл, шинэчлэлт төслийн 70,000.0 мянга, Мандал сум Зүүн хараа чиглэлийн 15.8 км хатуу хучилттай авто зам төслийн 801.2 мянга, нийт техник хяналтын зардлаас хэмнэгдсэн 70,801.2 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

3. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулалгүй нийт 101,350.6 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 17,785.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Балансын данстай холбоотой асуудал

- 1.1. **Илрүүлэлт:** Тайлант онд 17,785.1 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.
- 1.2. **Эрсдэл:** Хууль, журам мөрдөгдөхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдахгүй байх.
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

2.Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлттэй холбоотой асуудал

- 2.1. **Илрүүлэлт:** Төсвийн төслийг бодитой боловсруулаагүйгээс төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 5,646,441.7 мянган төгрөгөөр бууруулж 1,497,593.4 мянган төгрөгөөр баталсан байна.
- 2.2. **Эрсдэл:** Төсвийн төлөвлөлт бодитой бус байх, үр ашиггүй зарцуулах.
- 2.3. **Өгсөн зөвлөмж:** Төсвийг тооцоо судалгаа, гүйцэтгэлтэй уялдуулан бодитой төлөвлөж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж байх.
- 2.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Үндэсний хөгжлийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/359/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Үндэсний хөгжлийн газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Алтай-Дарви чиглэлийн 98км, 165 км хатуу хучилттай авто зам төслийн техникийн хяналтаас хэмнэгдсэн 3,039,347.9 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна. /Завсрын аудит/	3,039,347.9	Төлбөрийн акт	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Х.Батжаргал М.Бямбахишиг
2	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчин тайлант онд 17.8 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна.	17,785.1	Зөвлөмж өгөх	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Х.Батжаргал М.Бямбахишиг
3	Чойр дэд станцын өргөтгөл, шинэчлэлт төслийн 70.0 сая, Мандал сум Зүүн хараа чиглэлийн 15.8 км хатуу хучилттай авто зам төслийн 0.8 сая, нийт техник хяналтын зардлаас хэмнэгдсэн 70.8 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	70,801.2	Төлбөрийн акт	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Х.Батжаргал М.Бямбахишиг
4	Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулалгүй нийт 101,350,600 (нэг зуун нэг сая гурван зуун тавин мянга зургаан зуун) төгрөгийн шууд гэрээ байгуулсан байна.	101,350.6	Албан шаардлага	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Х.Батжаргал М.Бямбахишиг
5	Төсвийн төслийг бодитой боловсруулаагүйгээс төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 5,646.4 сая төгрөгөөр бууруулж, 1,497.6 сая төгрөгөөр баталсан байна.	0	Зөвлөмж өгөх	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Х.Батжаргал М.Бямбахишиг
ДҮН		3,229,284.8			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 23

№ 03/А0160056

Улаанбаатар хот

САГ-2021/359/СТА-ПчЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Үндэсний хөгжлийн газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Чойр дэд станцын өргөтгөл, шинэчлэлт төслийн 70,000,000 төгрөг, Мандал сум Зүүн хараа чиглэлийн 15.8 км хатуу хучилттай авто зам төслийн 801,200 төгрөг, нийт техник хяналтын зардлаас хэмнэгдсэн 70,801,200 төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Техник хяналтын дансны зарцуулагдаагүй үлдэгдэл 70,801,200 /далан сая найман зуун нэг мянга хоёр зуун/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь Аудитын хяналт шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Үндэсний хөгжлийн газрын дарга Х.Батжаргал, ерөнхий нягтлан бодогч М.Бямбахишиг нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
А.ДАВААДОРЖ
Ц.ЦЭРЭНХҮҮ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэн дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

10.10.10.20-Bichig_Khereg_Aki-2021-0223auditin 2-R Газар3.Docx

001090369



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 06 дугаар сарын 23

№ 04/10160056

Улаанбаатар хот

ОХГ-2021/359/СГД-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Үндэсний хөгжлийн газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулалгүй нийт 101,350,600 (нэг зуун нэг сая гурван зуун тавин мянга зургаан зуун) төгрөгийн шууд гэрээ байгуулсан байна;

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх;
2. Биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Үндэсний хөгжлийн газрын дарга Х.Батжаргал, ерөнхий нягтлан бодогч М.Бямбахишиг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

(Handwritten signature and stamp)

Ц.НАРАНЧИМЭГ
А.ДАВААДОРЖ
Ц.ЦЭРЭНХҮҮ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\0.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2021\0223auditin 2-R Газар 1.Docx

001080833

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.

[illegible]

[illegible]